



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/33

Шивээговь сум

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5, 35 дугаар зүйлийн 35.1.1, 35.1.2, Засгийн газрын 2024 оны 63 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын 2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх "Өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх ажил"-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:

Д.Отгонжаргал

(Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүн:

П.Ганжаргал

(Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, малын үржил, бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Д.Баттуул

(Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх "Өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх ажил"-аар худалдан авч буй бараа бүтээгдэхүүнийг шаардлагад нийцсэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулж, захиалагчаас гаргасан ажлын даалгаврын дагуу хүлээн авч, тайлагнахыг ажлын хэсгийн гишүүдэд үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн (М.Гантуяа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Ч.СУГАРМАА

